

ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТТАЙ ИРГЭДИЙГ ВИЗЭЭС ХАРИЛЦАН ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ИНДОНЕЗИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Индонези Улсын Засгийн газар (цаашид “Талууд” гэж нэрлэнэ),

Хоёр улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэхийг эрмэлзэн,

Албан ажлаар хоёр улсын хооронд иргэд зорчих явдлыг хөнгөвчлөхийг хүсч,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Визээс чөлөөлөх

Хүчин төгөлдөр дипломат буюу албан паспорт бүхий аль нэг Талын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт визгүй зорчих бөгөөд 14 хоногоос илүүгүй хугацаагаар байна.

2 дугаар зүйл

Виз олгох

1. Аль нэг Талаас нөгөө Талд суугаа Дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт томилогдсон хүчин төгөлдөр дипломат буюу албан паспорт бүхий ажилтанд оршин суух хугацаанд нь хүчин төгөлдөр үйлчлэх визийг тухайн Дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн нөгөө Тал олгоно.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хөнгөлөлтүүдийг түүнтэй адилтгах ангилал бүхий паспорт эзэмшигч ажилтнуудын гэр бүлийн гишүүн, гэр бүл болоогүй, 21-ээс доош насны хүүхдүүд эдлэх бөгөөд хүүхдийн нэр эцэг буюу эхийн паспортад бичигдсэн байвал зохино.

3 дугаар зүйл

Визийн хугацаа

Аль нэг Талын иргэдийн паспортын хүчин төгөлдөр байх хугацаа нь нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэх хүртэл сүүлийн 6 сарын хугацаанд хүчинтэй байна.

4 дүгээр зүйл

Орох ба гарах

Аль нэг Талын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт олон улсын зорчигч тээврийн бүх нээлттэй боомтоор нэвтэрнэ.

5 дугаар зүйл

Албан тушаалтны эрх буюу түр зогсоох

1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу виз авахаас чөлөөлөгдсөн аливаа этгээдийг тааламжгүй этгээд гэж үзсэн бол аль ч Тал түүнийг нэвтрүүлэхээс татгалзах, эсхүл оршин суух явдлыг нь зогсоох эрхтэй.

2. Аль ч Тал нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах үүднээс энэхүү Хэлэлцээрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болно. Ийнхүү арга хэмжээ авах тухайгаа нөгөө Талд нэн даруй дипломат шугамаар урьдчилан мэдэгдэнэ.

6 дугаар зүйл

Паспортын загвар

1. Талууд тэдгээрийн хүчин төгөлдөр паспортын загварыг дипломат шугамаар харилцан солилцоно.

2. Хэрэв аль нэг Тал өөрийн паспортыг өөрчлөхөөр бол шинэ паспортыг хэрэглэхээс өмнө загварыг нь нөгөө Талдаа илгээнэ.

7 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох, хугацаа, маргааныг шийдвэрлэх

1. Энэхүү Хэлэлцээр нь Талууд дотоодын хууль тогтоомжийн дагуу түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай бүх арга хэмжээ авсан тухай дипломат шугамаар харилцан мэдээлсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Хэлэлцээр нь 2 жилийн турш хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд Талууд бичгээр харилцан тохиролцсоноор цаашид 1 жил мөрдөж болно.

3. Энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг тайлбарлахад маргаан гарвал Талууд харилцан зөвшилцөх буюу хэлэлцэх замаар асуудлыг шийдвэрлэнэ.

4. Хэрэв шаардлагатай гэж үзвэл Талууд харилцан бичгээр тохиролцсоноор энэхүү Хэлэлцээрт нэмэлт буюу өөрчлөлт оруулж болно. Уг нэмэлт, өөрчлөлт нь Талуудын тогтоосон өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэнэ.

Дээрхийг нотолж, Засгийн газраас эрх олгогдсоны дагуу энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү Хэлэлцээрийг 2002 оны 10 дугаар сарын 7-ны өдөр Жакарта хотноо монгол, индонези, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи эхийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС**

**БҮГД НАЙРАМДАХ ИНДОНЕЗИ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС**

Гарын үсэг

Гарын үсэг